

モンゴル国の有形歴史文化遺産（考古学的遺跡）の保護と活用

В.ツォグトバートル
モンゴル科学アカデミー考古学研究所

あらゆる国民の歴史文化遺産、種は、人類共通の遺産であり、現在および将来の世代の利益や関心のための登録、保存、および保護について、国際法に明確に反映されている。

モンゴル国の歴史文化的遺産を探索、登録、研究、ランク付け、評価、保存、普及、修復の点から規定した「文化遺産保護法」の4条1項では文化遺産を有形と無形とに分ける、4条2項では有形文化遺産を不可動文化財と可動文化財とに分けると定義されている。

現在のモンゴル国の広大な領土には、歴史上のさまざまな時代の何千もの考古学的遺跡が残され、太古から人々が継続的に生活を営んでいたことを証明している。この文化遺産を研究、保存、および利用するためのすべての関係は、上記の法的規定の枠組みの中で規制されている。

本発表では、有形文化遺産（考古学的遺跡）の保護と活用の現状を、モンゴル国の有形歴史遺産の法的根拠、考古学的モニュメントの主な種類と年代、それらの登録とドキュメンテーション、リスク条件、博物館・歴史文化観光での利用の可能性という文脈で簡単に紹介する。

さらに、日本・モンゴルの50年にわたる外交関係の一部となってきた日本とモンゴルの文化交流にも言及し、1990年から始まった両国の考古学者間の交流、共同事業の成果、将来の方向性にも触れたい。

近年のモンゴル研究に多くの国々の考古学者が参入し、その数は年々増加しているが、そのなかでも日本とモンゴルの研究者の協力が中心的位置を占めていることは喜ばしい。

Монгол Улсын түүх, соёлын биет өв (археологи дурсгал)-ийн хамгаалалт, ашиглалт

Б.Цогтбаатар
Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи
Археологийн хүрээлэн

Аливаа улс үндэстний түүх соёлын өв, төрөл зүйл нь хүн төрөлхтөний нийтлэг өв бөгөөд өнөө болон хойч үеийн ашиг сонирхолын үүднээс хүлээн зөвшөөрч, хадгалж баталгаажуулах, хамгаалах тухай олон улсын эрх зүйн актуудад тодорхой тусгагдсан байдаг.

“Монгол Улсын түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах харилцааг зохицуулдаг “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн 4.1-д; Соёлын өвийг биет ба биет бус гэж ангилна. 4.2-т; Соёлын биет өвийг түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйл гэж ангилна гэж тодорхойлсон.

Өнөөгийн Монгол орны өргөн уудам газар нутагт нэн эрт үеэс хүн тасралтгүй оршин амьдарч ирсэний баталгаа болох түүхийн өөр өөр цаг үед холбогдох олон мянган археологийн дурсгалууд хадгалагдаж байдаг. Энэхүү өв соёлыг судлах, хадгалж хамгаалах, ашиглах бүх харилцааг дээр дурьдсан хуулийн заалтын хүрээнд зохицуулдаг.

Энэ илтгэлээр Соёлын биет өв (археологи дурсгал)-ийн хамгаалалт, ашиглалтын өнөөгийн байдлыг, Монгол улсын нутагт түүх соёлын биет өвийн хууль эрх зүйн үндэслэл, археологийн дурсгалын голлох төрөл зүйл, холбогдох он цагийн хамаарал, тэдгээрийн бүртгэл баримтжуулалт, эрсдэлийн нөхцөл, музей ба түүх соёлын аялал жуулчлалд ашиглах боломж сэдвийн хүрээнд товч танилцуулна.

Түүнчлэн Япон улс, Монгол улсын хооронд дипломат харилцаа тогтоосоны 50 жилийн түүхийн салшгүй нэгэн хэсэг болох Япон Монголын соёлын харилцааны хэлэлцээр, 1990 оноос эхлэлтэй хоёр орны археологичдын харилцаа, хамтын ажиллагааны зарим үр дүн, цаашдын чиг хандлагын талаар ч дурьдах болно.

Орчин үеийн Монгол судлалд олон улсын археологич эрдэмтэдийн оролцоо, хувь нэмэр жил ирэх тутам өсөн нэмэгдэж буй бөгөөд түүнд Япон-Монголын судлаачдын хамтын ажиллагаа бодитой байр суурь эзэлж байгааг тэмдэглэхэд таатай байна.